



MOTCAPITAL

Мэдээллийн Аюулгүй Байдлын Бодлого

Улаанбаатар хот

Нэмэлт, Өөрчлөлт

Он,сар, өдөр	Зүйл, заалт	Өөрчлөлт	Хувилбар
2025.01.01		Шинэчилсэн найруулга	1.0

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичигт MOT Капитал ХХК / цаашид “Компани” гэх/ Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг тодорхойлов.
- 1.2. Компани нь байгууллагын мэдээлэл болон хэрэглэгч, харилцагчдын хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор ISO/IEC 27001 стандартад суурилсан Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (МАБМТ)-г нэвтрүүлж байна.
- 1.3. Энэхүү Мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь Компанийн удирдлагууд, ажилтнууд, харилцагч компани болон гуравдагч этгээдүүдэд хамаарч, байгууллагын бүх мэдээллийн систем, тэдгээрийн ашиглалт, хамгаалалттай холбоотой үйл ажиллагаа, үйл явцад үйлчилнэ. Бодлогын хэрэгжүүлэлт нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, сонирхогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн шаардлагыг мөрдөхөд чиглэгдэнэ.

ХОЁР.МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА

- 2.1. Компани нь мэдээллийн аюулгүй байдалд тавигдах шаардлагуудыг удирдлагын зөвшилцлийн үндсэн дээр тодорхойлж, хадгална. МАБМТ-ийн үйл ажиллагаа нь эдгээр шаардлагыг биелүүлэхэд чиглэгдэнэ. Мөн хууль тогтоомж, зохицуулалт, болон гэрээний шаардлагуудыг баримтжуулж, төлөвлөлтийн явцад тусгаж, шинэ болон өөрчлөгдсөн систем, үйлчилгээний аюулгүй байдлын шаардлагыг төсөл боловсруулалтын эхэн үеэс хэрэгжүүлнэ.
- 2.2. Компанийн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны үндсэн зарчим нь хэрэгжиж буй хяналтыг бизнесийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн явуулдаг бөгөөд үүнийг Мэдээллийн аюулгүй байдлын ажлын хэсгийн хурал, мэдээлэл өгөх баримт бичгүүдээр дамжуулан нийт ажилтнуудад тогтмол мэдэгддэг байна.

ГУРАВ.МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ НЭВТРҮҮЛЭХ ЗОРИЛТ

- 3.1. Компани нь мэдээллийн аюулгүй байдлыг нэвтрүүлэх дараах зорилтуудыг тодорхойлж байна.Үүнд:
 - 3.1.1. Мэдээллийн нууцлалыг хангах: Хэрэглэгчдийн болон байгууллагын мэдээллийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалах.
 - 3.1.2. Мэдээллийн хүртээмжийг сайжруулах: Бүх мэдээлэл шаардлагатай үед найдвартай, аюулгүйгээр хүртээмжтэй байх.
 - 3.1.3. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах: Мэдээллийг алдаагүй, бүрэн бүтэн байлгах.
 - 3.1.4. Эрсдэлийг бууруулах: Болзошгүй эрсдэлүүдээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх.
 - 3.1.5. Хууль эрх зүйн шаардлагыг хангах: Мэдээллийн аюулгүй байдлын хууль тогтоомж, шаардлагыг дагаж мөрдөх.

ДӨРӨВ.МАБМТ-Г ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАХ

- 4.1. Компани нь Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог (МАБМТ) тасралтгүй сайжруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.Үүнд:
 - 4.1.1. Тогтмол эрсдэлийн үнэлгээ: Эрсдэлийг тогтмол үнэлж, үр дүнгийн дагуу шинэ хяналт, арга хэмжээг нэвтрүүлэх.
 - 4.1.2. Дотоод болон гадаад аудит: МАБМТ-ийн гүйцэтгэлийг тогтмол хянаж, сайжруулах санал дэвшүүлэх.
 - 4.1.3. Сургалт, мэдлэгийн дээшлүүлэлт: Ажилтнуудын мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг тогтмол нэмэгдүүлэх.
 - 4.1.4. Технологийн шинэчлэл: Дэвшилтэт технологи, шийдлүүдийг ашиглан аюулгүй байдлыг сайжруулах.

- 4.1.5. Үр дүнгийн хяналт, хэмжилт: МАБМТ-ийн зорилт, гүйцэтгэлийг хэмжиж, хэрэгжилтийг хянах.
4. 2. Сайжруулах санааг ажилтан, хэрэглэгч, харилцагч, мэдээллийн технологийн ажилтнууд, эрсдэлийн үнэлгээ, үйлчилгээний тайлан зэрэг төрөл бүрийн эх сурвалжаас авч болно. Тодорхойлсон тохиолдолд бүртгэл үүсгэж, удирдлагын дүн шинжилгээний нэг хэсэг болгон үнэлж баталгаажуулна.

ТАВ.ХАРИУЦЛАГА

5. 1. Хэлтсийн удирдлагууд нь мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах шаардлагатай арга хэмжээг авна.
5. 2. Энэхүү бодлогод заасан хэм хэмжээг зөрчсөн ажилтанд уг зөрчлийн эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс хамаарч Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан сахилгын шийтгэлийн аль нэгийг шат дараалал харгалзахгүйгээр шийдвэр гаргаж ногдуулна.
5. 3. МАБМТ-ны дагуу мэдээллийг санаатай буюу санамсаргүй байдлаар бусдад задруулснаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх түүнчлэн Зөрчлийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулийн зохих заалтын дагуу асуудлыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ooOoo



www.motcapital.com
support@motcapital.com